



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 1 сарын 09 өдөр

Дугаар 01

Улаанбаатар

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 61.3, 61.4, 61.9, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дүгээр зүйлийн "Б" хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагаас компанийн байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:

Хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн ирүүлсэн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас 272,775 ширхэг энгийн хувьцааг хасаж Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссын дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад:	Л.Буянбат	ТУЗ-ийн дарга
Гишүүдэд:	С.Итгэл	ТУЗ-ийн гишүүн
	Ж.Чимэдцэрэн	ТУЗ-ийн гишүүн
	Ш.Мөнх-очир	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

4. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комисст даалгах нь:
 - Ээлжит бус хурал хуралдуулах тухай зар мэдээг 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, радио, телевиз болон Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх.
 - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх.
 - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж (ХК) компанид 2015 оны 01 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлэх.
 - Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажиллагааг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий брокер, дилерийн компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах.



- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудас, түүнтэй холбогдох баримт бичгийг тэдний үйлчлүүлдэг брокер, диллерийн компанид тогтоосон хугацаанд хүргүүлэх.
 - Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, холбогдох бичиг баримт, гарах шийдвэрийн төслийг 2015 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 02 дугаар сарын 04-ний өдрийг дуустал 09-13, 14-17 цагт компанийн байранд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах.
- 5 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
 - 6 Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
 - 7 Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.
 - 8 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батхуягийг сонгосугай.
 - 9 Хурлын тооллогын комиссын даргаар Д.Минжмаа, гишүүнээр Н.Гомбосүрэн, П.Сансартуяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



П.БУЯНБАТ



**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Ээлжит бус хурал хуралдах өдөр, эхлэх цаг: 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр
Хурал эхлэх цаг: 10:00 цаг
Хурал хуралдах газар: Тахько (ХК) компанийн байранд
Хувьцаа эзэмшигчийн (эцэг, эхийн) (нэр)
Регистрийн дугаар Хувьцааны төрөл (энгийн, давуу)
Хувьцааны тоо Дансны дугаар

Ердийн аргаар санал авах асуудал

№	Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн товч утга	Зөвшөөрсөн (+)	Татгалзсан (+)	Түдгэлзсэн (+)
	Хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн ирүүлсэн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас хувьцаа эзэмшигч асан Ц.Настын 87,087, Т.Доржготовын 87,087, Ш.Мөнх-Очирын 98,606 ширхэг энгийн хувьцааг хасаж Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах 1			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, нэр ()

Санал авах хуудсыг үйлдсэн оны дугаар сарын -ны өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцож тоолсон тооллогын комиссын дарга ()

Хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан
.....
.....

Санал өгөх хуудас бөглөх зөвлөмж:

- Саналын хуудасны асуултад зөв хариулж ямар нэг засваргүйгээр бичилтийг үйлдэнэ.
- Зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн аль нь болох тухай саналаа + гэж тэмдэглэнэ.
- Саналын хуудсыг хувьцаа эзэмшигч өөрөө бөглөж санал өгнө.
- Бусдыг төлөөлж санал өгөхгүй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын
15-ны өдрийн 34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН
МЭДЭГДЭЛ**

Компанийн нэр: *Тахько (ХК) компани*

Хаяг, утас: *Улаанбаатар 211238, Чингэлтэй дүүрэг,
5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18
Гар утас: 9911 3181, 9911 8419
Утас/факс: 325051*

Ээлжит бус хурал хуралдах
огноо, цаг, газар: *2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн
10:00 цагт компанийн байранд*

Ээлжит бус хурал хуралдуулах
шийдвэр гаргасан огноо: *2015 оны 01 дүгээр сарын 09*

Олон нийтэд зарлах огноо: *2015 оны 01 дүгээр сарын 13*

Бүртгэх өдөр: *2015 оны 01 дүгээр сарын 23*

Гэрээний дагуу хурлын баримт
бичгийг брокер, дилерийн
компанид хүргүүлэх огноо: *2015 оны 01 дүгээр сарын 14-16*

Хүргүүлсэн огноо:

Ээлжит бус хурлын баримт бичгийн хуудасны тоо хуудас

**ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИССЫН ДАРГА**



(Л.БУЯНБАТ)

2015 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр

**ХҮЛЭЭН АВСАН
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН**

(.....)

2015 оны дүгээр сарын-ний өдөр

**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2015 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 05-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД БЭЛТГЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийх ажлын утга	Хугацаа	Хаана
1.	Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулах, холбогдох шийдвэрийг гаргах <ul style="list-style-type: none"> Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол Санал авах хуудасны загварыг батлах 	2015.01.09.	Компанийн байранд
2.	ТУЗ-ийн хурлын материалыг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж /ХХ/ компанид хүргүүлэх <ul style="list-style-type: none"> Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол Санал авах саналын хуудасны загвар Ээлжит бус хурал хуралдуулах тухай мэдэгдэл Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд мэдээлэх зарын загвар Хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгээс ирүүлсэн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлага 	2015.01.09.	СЗХ, Хөрөнгийн Бирж
3.	Ээлжит бус хурал хуралдуулах тухай зар мэдээг өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, радио, телевиз болон Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх (ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 5 хоногийн дотор)	2015.01.13.	Хөрөнгийн Бирж Монголын Үнэн, Зууны мэдээ, ТВ-9 телевиз
4.	Энэхүү зар мэдээг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх	2015.01.28.	Хөрөнгийн Бирж Монголын Үнэн, Зууны мэдээ, ТВ-9 телевиз
5.	Ээлжит бус хурлын баримт бичгийг танилцуулж, санал авах ажиллагааг зуучлан гүйцэтгэх гэрээг Брокер, дилерийн компанитай байгуулах	2015.01.12.	"Таван Богд" БДК
6.	Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудас, бусад холбогдох материалыг БДК-д хүргүүлэх (зар мэдээг нийтэд анх хүргэсэн өдрөөс хойш 5 хоногийн дотор)	2015.01.17.	"Таван Богд" БДК
7.	Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэл судалгааг 2015/01/23-ны өдрөөр тасалбар болгон авах	2015.01.23.	ҮЦТТТХ Төв
8.	Ээлжит бус хурлын материалыг гаргасан шийдвэрийн хамт хурал хуралдсанаас хойш 20 хоногийн дотор хүргүүлэх	2015.02.25.	СЗХ, Хөрөнгийн Бирж

ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
Харилцах утас, факс: 99113181, 99113624, 325051



Ээлжит бус хурлын зарын загвар



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагаас компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18)-нд хуралдуулж, тус компанийн хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгийн санал, шаардлагын дагуу Тахько (ХК) компанийн нийт хувьцаанаас 272,775 ширхэг энгийн хувьцааг хасаж Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хувьцаа эзэмшигчдийг 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдөр хүртэлх хугацаанд ажлын цагаар тус тусын үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байранд ирж хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөр, хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагаар тус тус тогтоосон болно.

ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС
Харилцах утас, факс: 99113181, 99113624, 325051



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АСУУДЛЫН ТАНИЛЦУУЛГА

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Жамбаа овогтой Чимэдцэрэн нь компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай шаардлагыг Төлөөлөн удирдах зөвлөлд 2014 оны 12 дугаар сарын 24-нд ирүүлсэн юм.

Ж.Чимэдцэрэн нь уг санал, шаардлагандаа Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч асан Ц.Наст, Т.Доржготов, Ш.Мөнх-Очир нарын 272,775 ширхэг хувьцааг Тахько (ХК) компанийн хөрөнгө оруулалттай Татекс (ХХ) компанийн нийт хөрөнгө, Тахько (ХК) компаниас нэмж шилжүүлэн өгсөн зарим хөрөнгө, нийт 310,996,710 төгрөгийн хөрөнгөөр үүсгэн байгуулагдсан гэж үзэж дээрх 272,775 ширхэг хувьцааг Татекс (ХХ) компанид шилжүүлэн, Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах саналыг Төлөөлөн удирдах зөвлөлд гаргасан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь дээрх шаардлагын дагуу 2015 оны 01 дүгээр сарын 09-нд хуралдаж, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 61.3, 61.4, 61.9 дэх заалт, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.2.2 дүгээр зүйлийн "б" хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гаргасан болно.

Тахько (ХК) компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 1995 оны 02 тоот тогтоолоор Тахько (ХК) компани, Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компанитай хамтран оёдлын үйлдвэрүүдийг байгуулахаар шийдвэрлэн хоёр талын хамтарсан хөрөнгө оруулалттай "Айтекс", "Татекс" компаниудыг 10 жилийн хугацаатайгаар байгуулж, Тахько (ХК) компанийн 1996 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дээрхи шийдвэрийг баталсан байна. Улмаар хөрөнгө оруулагч талуудын шийдвэрээр 2000 оноос Тайваны "Грэйт Айвэн Ко. Лтд" компани "Айтекс" оёдлын үйлдвэрийг, Тахько (ХК) компани "Татекс" оёдлын үйлдвэрийн үйл ажиллагааг тус тус хариуцан ажиллаж эдгээр 2 компани нь 2005 онд үйл ажиллагаагаа зогсоосон юм. Тахько (ХК) компанийн нэр бүхий 3 хувьцаа эзэмшигч нь 2000 оны 04 дүгээр сарын 12-ны хэлэлцээрээр Тахько (ХК) компанийн эзэмшлийн хамтарсан хөрөнгө оруулалттай "Татекс" компанийн үйл ажиллагааг хариуцан түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн компани тусгаарлах хэлбэрээр ажилласан билээ.

Хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэн нь дээрх 2000 оны 04 дүгээр сарын 12-ны хэлэлцээрээр Тахько (ХК) компаниас “Татекс” компанийг хуваагдсан гэж үзэж, Тахько (ХК) компанийн нэр бүхий 3 хувьцаа эзэмшигчдийн 272,775 ширхэг хувьцааг хасах замаар Тахько (ХК) компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах саналыг гаргаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж байна.

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигч Та энэ удаагийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, хувьцаа эзэмшигч Ж.Чимэдцэрэнгээс ирүүлсэн санал, шаардлага, хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, хавсралтаар хүргүүлсэн саналын хуудсаар саналаа өгөхийг хүсье.

Ээлжит бус хурлын бүртгэх өдрийг 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөр тогтоосон тул энэ өдрөөр бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч ээлжит бус хуралд оролцох эрхтэй болно.

Ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төслийн талаар лавлах, дэлгэрэнгүй мэдээлэл авах зүйлээ утас, факс, цахим шуудангаар эсвэл 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл хугацаанд ажлын цагаар компанийн байранд ирж асууж танилцаж болно.

Ээлжит бус хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас хүлээж авах сүүлчийн хугацааг 2015 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 17:00 цагаар тогтоосон болно.

Хувьцаа эзэмшигч Таныг 2015 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10:00 цагаас Тахько (ХК) компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж 18)-нд хуралдуулахаар товлосон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд хүрэлцэн ирж оролцохыг урьж байна.

ЭЭЛЖИТ БУС ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Харилцах утас, факс, цахим шуудан

9911 3181, 9911 3624, 325051

munkhochir_sh@yahoo.com

